

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 13.020.01

Ховор ургамал тарималжуулах ерөнхий шаардлага	MNS 6191 : 2010
General requirements for cultivating rare plants	

Стандарчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 28- ны өдрийн 41 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ховор ургамлыг хамгаалах, тарималжуулах зорилгоор түүж бэлтгэх, нөхөн сэргээх ажилд мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргадаг эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн ургамал судлаач багш, эрдэмтэд болон байгалийн ургамлыг хамгаалах, тарималжуулах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөхөд хамаарна.

## 2 Зорилго

Ховор ургамлын тархац, байршил, гарц, нөөцийг тогтоон судалж, нөхөн сэргээх, тарималжуулах замаар байгаль дахь нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, тогтвортой ашиглах боломжийг бүрдүүлэхэд оршино.

## 3 Норматив ишлэл

Энэ стандартад иш татсан суурь стандарт, бусад баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлээс иш татаж хэрэглэнэ.

- MNS1-1: 2006 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо, 1-р хэсэг: Техникийн ажлын журам
- MNS 1-2: 2006 Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо, 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм
- MNS 2430: 2009. Мод сөөгний үр. 1000 үрийн жинг тодорхойлох арга.
- MNS 2429: 2009. Мод сөөгний үр. Үрийн дээж авах арга.
- MNS 487: 2001. Тарих үрийн чанарыг тодорхойлох арга.
- ОУСБ-ын арга зүйн удирдамж 64, Бүтээгдхүүний стандартад байгаль орчны асуудлыг багтаасан арга зүйн зөвлөмж.
- Ц. Даваажамц. Говьд хайлаасыг үрээр тарьж судалсан дүн ба тариалах товч заавар. Улаанбаатар. 1965.
- У. Лигаа ба бусад. Монгол орны ховор ургамлын зурагт лавлах. Улаанбаатар. 2009.
- Г. Очирбат. Ургамлын интродукци. Улаанбаатар. 2001.
- Ю. Оюунбилэг. Урал чихэр өвс, Эгэл өмхий өвсийг эс эдийн өсгөврөөр үржүүлэх нь. Биологийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. 2008.
- Р. Циммэрманн, Д. Ариунгэрэл. Эмийн болон үнэрт ургамлыг тариалах ба түүх заавар. Улаанбаатар. 2008.

## **MNS 6191:2010**

- Г. Эрдэнэжав. Ботаник, ургамлын аж ахуйн судалгааны үр дүн ба хэтийн төлөв. Улаанбаатар. 2005.

### **Нэр томьёо, тодорхойлолт**

#### **4.1 Ховор ургамал**

Байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац нөөц багатай, устаж болзошгүй ургамал.

#### **4.2 Ховор ургамлын жагсаалт**

Байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац нөөц багатай, устаж болзошгүй ургамлын нэрсийг Засгийн газраас батлан гаргасан баримт бичиг.

#### **4.3 Ургамал тарималжуулах**

Байгалийн ямар нэгэн зүйл ургамлыг тархац нутагт нь болон өөр нутагт тарьж ургуулах үйл ажиллагаа.

#### **4.4 Үр**

Цэцэгт ургамлын үрт нахианаас үүсэлтэй, ургамлын үржил, тархалтын эрхтэн.

#### **4.5 Амьд суулгац**

Ургамлын үндэслэг иш, мөчир, булцуу, сонгинолог иш зэрэг ургал эрхтнүүд болон бүтэн ургамал.

#### **4.6 Эксплант**

Эс, эдийн өсгөвөр хийхэд ашиглагдах ургамлын өврийн нахиа, оройн нахиа, иш, навч, үр, үндэс, үрийн тал гэх мэт эрхтэн.

#### **4.7 Вегетацийн хугацаа**

Улирлын уур амьсгалтай газар нутагт ургамлын ургалт, өсөлт хамгийн эрчимтэй явагдах хугацаа.

### **5 Ерөнхий шаардлага**

**5.1** Тархац нөөц нь эрс багассан, нэн тэргүүнд нөхөн сэргээх шаардлагатай ховор ургамлыг тарималжуулна. Тарималжуулах ховор ургамлыг төв, орон нутгийн болон эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сонгоно.

**5.2** Ховор ургамлыг тарималжуулахад ашиглагдах үр, амьд суулгац, эксплантийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгалиас түүж бэлтгэнэ.

**5.3** Сонгосон ургамлын биологи онцлогийг судалж, тархац, байршил, гарц, нөөцийг тогтоон, ургах орчны экологи, цаг уур, хөрсний нөхцлийг тодорхойлно. Мөн тухайн ургамлын ховордож буй шалтгаан, хамгаалах талаар судалж, мэдээлэл цуглуулна.

**5.4** Байгаль дахь ургамлаас үр, амьд суулгац, эксплантийг бэлтгэхдээ тодорхой зүйлийн популяцийн ялгавраар тусгайлан түүнэ. Түүхдээ популяцийн нийт бодгалийн 80-аас доошгүй хувьд гар хүрэлгүй үлдээнэ.

**5.5** Үр, амьд суулгац, эксплантийн ургах чадварыг алдагдуулахгүйгээр савлаж тээвэрлэх ба савны гадна талд ургамлын шинжлэх ухааны нэр, цуглуулсан газар

(аймаг, сум, газрын нэр, газарзүйн солбицол, өндөршил, налуу), ургах орчин болон хөрсний тухай мэдээлэл, огноо, бэлтгэсэн ажилтны нэр бүхий баримтжуулах шошготой байна.

**5.6** Ургамал тарималжуулах үйл ажиллагаа нь тухайн ургамлын онцлогоос шалтгаалан 5-6 жил, түүнээс олон жил үргэлжилнэ.

## **6 Тусгай шаардлага**

**6.1** Ургамлыг үрээр тарималжуулах бол үрийг бүрэн боловсорсон үед, амьд суулгацыг хавар эрт юм уу намар, эксплантнийг зорилгоос хамаарч тохирох хугацаанд нь тус тус бэлтгэнэ.

**6.2** Ховор ургамал тарималжуулах талбайг цаг уурын нөхцөл, хөрсний онцлог, ус, дулаан, шим тэжээлийн бодисын хангамж зэргээс хамааруулан сонгох ба тарих талбайн хөрсийг тухайн ургамлын эх нутгийнхтай нь аль болох адил төстэй байхаар бүрдүүлнэ. Эд эсийн өсгөвөр хийх бол тохирох тэжээлийн орчныг бэлдэнэ.

**6.3** Үрийг эртжүүлэх, үрслэг бэлтгэх, булцууг хөөлгөх зэргээр үр, амьд суулгацыг тарилтанд бэлтгэх ба тэдгээрийг ариутгасан байна.

**6.4.** Ховор ургамлын генофондыг хадгалахын тулд тарималжуулах үйл ажиллагааны явцад санаатай болон санамсаргүй эрлийзжилт явагдахаас сэргийлнэ.

**6.5** Ургамлын явцад услах, бордох, сийрүүлэх, сүүдэрлэх, өвөлжилтөнд бэлтгэж дулаалах зэрэг арчилгааг ургамал тус бүрийн онцлогт тохируулан хийнэ.

**6.6** Тариалалт хийсний дараа ургаж буй хөврөс, иш, найлзуурын үүсэл, өсөх хугацаа, хэмжээг 10 хоног тутамд хэмжиж, статистик боловсруулалт хийнэ. Баг цэцэг, цэцгийн нахиа үүсэх хугацаа, өсөлтийг ажиглан ид цэцэглэлт, тоос хүртэлт, тоосны бүтэц, үр боловсрох орны өөрчлөлт, үр суух, үр жимс боловсрох хугацааг тогтоож, нэг найлзуур, нэгж ургамал дээрхи цэцэг, үр жимсний тоог тодорхойлно. Зарим ургамал эхний жил цэцэглэхгүй, 2-3, түүнээс олон жилийн дараа цэцэглэдэг учир тухайн жилийн бие, иш, навч, найлзуур, салаалалт, нөхөн сэргэлт зэргийг нэг бүрчлэн тооцоолно. Мөн үндэсний өсөлт, салаалалт, газрын доорх бусад эрхтний өсөлт, хөгжилтийг ажиглан (вегетацийн төгсгөлд) бүртгэнэ.

**6.7** Вегетацийн төгсгөлд тухайн ургамлын онцлогт тохирсон нөхцөлд (хучлагатай, хучлагагүй гэх мэт) өвөлжүүлнэ.

**6.8** Байгалиас бэлдсэн үр, амьд суулгац, эксплантаар тарьсан ургамлын дотроос тухайн нөхцөлд ургах ирээдүйтэй ургамлыг сонгон авч, цааш үржүүлэн олшруулна. Тэдгээрээс үр, амьд суулгац, эксплант бэлдэж, стандарт, аргазүйд нийцсэн нөхцөлд хадгална.

**6.8** Ургамал тус бүрийн тариалалтын агротехникийн нөхцлийг тодорхойлж, тухайн ховор ургамлыг тарималжуулах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллана.

**ТӨГСӨВ.**